



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 05 сарын 27 өдөр

Дугаар А/259

Чингис хот

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.5-ын "а", Соёлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.2, Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.20 дахь заалт, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Соёлын биет бус өвийг түгээн дэлгэрүүлэх зорилгоор "Өрх бүрт-Өв соёл" цахим уралдаан болон Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийн баярын арга хэмжээнд зориулж 580000 (таван зуун наян мянга) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Хөрөнгө зарцуулалтын тооцоог хавсралтаар баталсугай

3. Дээрх арга хэмжээнд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн урьдчилан төлөвлөх боломжгүй нэг удаагийн шинжтэй арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг нийгмийн бодлогын хэлтсийн дарга (Г.Лхагвахатан)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

231011590

Аймгийн Засаг даргын 2021 оны
05 дугаар сарын 27 өдрийн А/259
дугаар захирамжийн хавсралт

Арга хэмжээний зардлын тооцоо

№	Зардлын нэр	Мөнгөн шагналын дүн	Нийт дүн
1	"Өрх бүрт-Өв соёл" цахим уралдааны зардалд	250000	250000
2	Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийн баярын арга хэмжээнд	330000	330000
3	Бүгд дүн	580000	